



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2022 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/30

Ховд

**Үнэлгээний хороо байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 103 дугаар журам, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын А/03 дугаар журмуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Барилга хот байгуулалтын яамнаас эрх шилжиж ирсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сумын тохижилт (Ховд, Дуут сум)-ын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Ц.Даваасамбуу	- Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн
Гишүүдэд:	Б.Далайбаяр	- Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн
	Б.Энхболд	- Төрийн бус байгууллагын төлөөлөл
	Н.Чинбат	- Иргэний төлөөлөл
Нарийн бичиг:	Д.Дариймаа	- Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо (Ц.Даваасамбуу)-д даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг (Д.Дариймаа)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Д.ЭНХБОЛД